



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 371

Улаанбаатар хот

“Үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төсөл”-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 11 нэрийн, нийт 48,185,500.00 (дөчин найман сая нэг зуун наян таван мянга таван зуу) төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 16,260,450.00 (арван зургаан сая хоёр зуун жаран мянга дөрвөн зуун тавь) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төсөл”-ийн зохицуулагч Ж.Ганбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

ийн эмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн
321 дугаар тогтоолын хавсралт

“Хөгжлийн хөтөч дэд бүтэц” төслийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, үлдэх өртөггүй, ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шийнчлэн тогтоох хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Код	Ашиглалта д орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нийт үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон хугацаа (жилээр)
1	MacBook Air	00001195	2020.01.21	1	ш	9,200,000.00	9,200,000.00	2,890,000.00	2,890,000.00	2
2	Гадаа камер 360PTZ HIKVISION	00001091	2019.11.13	1	ш	6,081,900.00	6,081,900.00	1,824,570.00	1,824,570.00	2
3	Гадаакамер 360PTZ HIKVISION	00001092	2019.11.13	2	ш	1,835,900.00	3,671,800.00	550,770.00	1,101,540.00	2
4	Хяналтын камерын бичигч төхөөрөмж	00001094	2019.11.13	2	ш	240,900.00	481,800.00	72,270.00	144,540.00	2
5	Агаар цэвэршүүлэгч	00000327	2019.12.31	2	ш	1,460,000.00	2,920,000.00	730,000.00	1,460,000.00	2
6	Нивелир	00000510	2019.12.31	2	ш	1,570,000.00	3,140,000.00	471,000.00	942,000.00	2
7	Шимдтийн алх	00001145	2019.12.31	2	ш	2,450,000.00	4,900,000.00	735,000.00	1,470,000.00	2
8	Теодолит	00001146	2019.12.31	2	ш	3,518,000.00	7,036,000.00	1,055,400.00	2,110,800.00	2
9	Зөөврийн компьютер Dell XPS i7	00001147	2019.12.31	1	ш	9,500,000.00	9,500,000.00	3,690,000.00	3,690,000.00	2
10	Estimator Pro multi шинэчлэлт	00002066	2023.09.08	2	ш	495,000.00	990,000.00	247,500.00	495,000.00	1
11	Estimator Pro single шинэчлэлт	00002067	2023.09.08	1	ш	264,000.00	264,000.00	132,000.00	132,000.00	1
				18			48,185,500.00		16,260,450.00	
	НИЙТ ДҮН						(дөчин найман сая нэг зуун наян таван мянга таван зуун төгрөг)		(арван зургаан сая хоёр зуун жаран мянга дөрвөн зуун тавин төгрөг)	